

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ
2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:ДГА-2019/4/СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг Сайншанд сум
2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ariunaa.ch@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 99026829 Цахим хаяг: lundegmaa.ts@audit.gov.mn
Аудитор: Б.Эрдэнэтунгалаг
Утас: 99063931 Цахим хаяг: sain.audit5831@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	...
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	...
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	10

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.07 № 1-6/3138
танай _____-ны № _____-т

ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангматериаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

444190321

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ц.Золжаргалд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 4-нөөс 2019 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Сайн-Аудит ХХК ын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 4-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ нь ард иргэдэд эрүүл мэнд бөөрний сувилалын чанартай үйлчилгээг үзүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цайны газрын үйлчилгээ
- Зочид буудал амралтын газар
- Бүрдэнэ сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ААНОАТатварын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашиглаагүй excel ээр гаргасан байна.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд /Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн

8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын 2 хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь тайлант жилд алдагдалтай ажилласантай холбоотой юм.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-2018 оны *Нийт зардал* 275992.0 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 2,759.92 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь дундаж хувьтай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг Б401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горимсорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 0 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 11 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазар нь 2018 онд 98502.5 мянган төгрөгийн орлогыг олох төлөвлөгөөтэй ажилласнаас 83185.0 мянган төгрөгийн орлого олж төлөвлөгөөг 84 хувьтай төлөвлөгөөг биелүүлсэн байна.

Тайланд онд алдагдалтай ажилласан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал болон дахин үнэлгээний гарзаас шалтгаалсан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 50 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГазрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

- 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ -ЫН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Огноо: 2019.03.11

Үзүүлэлт	Үлдэгдэл	
	2018.01.01	2018.12.31
А.Хөрөнгө		
1.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,239,481.01	363,037.00
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Дансны авлага	-	-
Бусад авлага	709,745.70	1,613,779.95
Татвар, НДШ-ийн авлага	418,222.00	339,668.64
Бараа материал	64,514,133.85	60,124,484.00
Урьдчилж төлсөн зардал		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	7,892,700.00	7,533,850.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	74,774,282.56	69,974,819.59
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	777,687,791.00	411,285,894.00
Биет бус хөрөнгө	-	
Хайгуулын үнэлгээний хөрөнгө		
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө		
Бусад биет бус хөрөнгө /газар/		30,096,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	777,687,791.00	441,381,894.00
Нийт хөрөнгийн дүн	852,462,073.56	511,356,713.59
Өр төлбөр ба эздийн өмч		
Дансны өглөг	40,193.00	1,000,000.00
Цалингийн өглөг		-
Татварын өр	2,069,043.07	310,319.13
НДШ-ийн өглөг	-	
Банкны богино хугацаат зээл	-	-
Богино хугацаат өглөгийн дүн	2,109,236.07	1,310,319.13
Урт хугацаат зээл	9,700,000.00	9,700,000.00
Урт хугацаат өр төлбөрийн дүн		9,700,000.00
Нийт өр төлбөрийн дүн	2,109,236.07	11,010,319.13
ӨМЧ: а) төрийн	1,069,825,400.00	1,084,028,229.00
б) хувийн		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал	-	-
Хуримтлагдсан ашиг	(229,172,562.51)	(583,681,834.54)
Эздийн өмчийн дүн	840,652,837.49	500,346,394.46
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	842,762,073.56	511,356,713.59

**ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ -ЫН АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН
ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны орлого	83,612,554.52	83,185,058.23
Борлуулалтын өртөг	24,346,684.50	18,604,186.50
Нийт ашиг/алдагдал/	59,265,870.02	64,580,871.73
Хүүний орлого	0.00	0.00
Бусад орлого	1,388,300.00	0.00
Ерөнхий ба удирдлагын зардал	137,659,423.00	137,811,757.76
Санхүүгийн зардал	0.00	0.00
Дахин үнэлгээний гарз	17,493,063.03	281,278,386.00
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	-59,512,189.95	-354,509,272.03
Орлогын татварын зардал		
Татварын дараах ашиг	-59,512,189.95	-354,509,272.03

ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ -ЫН АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Огноо: 2019.03.11

Үзүүлэлт	/төгрөгөөр/	
	Өмнөх он	Тайлант он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	120,728,694.00	109,243,384.00
Борлуулсан бараа, үзүүлсэн үйлчилгээний орлого	91,973,809.97	81,156,765.23
Татаас санхүүжилтийн орлого		0.00
бусад орлого	28,754,884.03	28,086,618.77
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	119,747,950.00	110,119,828.01
Ажиллагчдад олгосон мөнгө	34,402,923.00	31,884,470.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	4,561,172.00	2,659,274.00
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	40,298,755.00	13,975,337.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	0.00	7,030,128.00
Түлш шатахуун , тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	4,650,000.00	3,894,260.00
Төлсөн хүү	63,800.00	81,582.00
Татварын байгууллагад төлсөн	17,489,600.00	12,784,810.37
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	217,200.00	217,200.00
Бусад мөнгөн зарлага	18,064,500.00	37,592,766.64
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	980,744.00	-876,444.01
Мөнгөн орлогын дүн	2,900,000.00	0.00
Банкнаас авсан зээл, үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,900,000.00	0.00
Мөнгөн зарлагын дүн	2,900,000.00	0.00
Зээлийн төлөлт	2,900,000.00	0.00
Улсаас өгсөн санхүүжилт		
Төрөл бүрийн хандив		
Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт		
Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа		
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		0.00
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	980744.00	-876,444.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	258737.01	1,239,481.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1239481.01	363,037.00

ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ -ЫН АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Огноо:
2019.03.11

Д/ д	Үзүүлэлт	/төгрөгөөр /		Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
		Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал		
1	2018 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,069,825,400.00	0.00	-229,172,562.51	840,652,837.49
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт / бууралт /				0.00
3	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт / бууралт /				
4	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц				
5	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	14,202,829.00			14,202,829.00
6	Тайлант үеийн цэвэр ашиг			-354,509,272.03	354,509,272.03
7	Өмчид гарсан өөрчлөлт				0.00
8	Гаргасан хувьцаат капитал				0.00
9	2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,084,028,229.00	0.00	-583,681,834.54	500,346,394.46